



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/042/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЛТАНЦӨГЦ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА А.ЕРХАНАТ ТАНАА

2025.02.25 № 266  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд 198.6 сая төгрөгийн үнэтэй, 117 нэр төрлийн элэгдлээ нөхсөн, элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй болсон хөрөнгө бүртгэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>252,936.60</u></b>	<b><u>39,362,945.69</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	252,936.60	252,936.60
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	252,936.60	252,936.60
3,351	Байгууллагаас авах авлага	252,936.60	252,936.60
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	134,609.09
<b>3,471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	134,609.09
34,713	Цалингийн урьдчилгаа	-	134,609.09
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	-	38,975,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	-	38,975,400.00
35,410	Бичиг хэргийн материал	-	350,000.00
35,420	Аж ахуйн материал	-	38,625,400.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,190,245,101.12</u></b>	<b><u>4,933,724,924.61</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>1,190,245,101.12</u></b>	<b><u>4,933,724,924.61</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>1,175,146,744.72</u></b>	<b><u>4,918,766,882.67</u></b>
39,201	Барилга, байгууламж, орон сууц	671,935,050.48	690,935,050.48
39,202	Хуримтлагдсан элэгдэл	(119,293,413.24)	(143,391,489.12)
39,203	Авто-тээврийн хэрэгсэл	112,140,000.00	488,725,000.00
39,204	Хуримтлагдсан элэгдэл	(108,159,999.88)	(121,553,666.49)
39,205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,276,071.00	401,949,121.00
39,206	Хуримтлагдсан элэгдэл	(254,857,617.50)	(268,913,745.74)
39,207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,495,218.00	43,495,218.00
39,208	Хуримтлагдсан элэгдэл	(27,799,338.16)	(29,302,447.60)
39,209	Зам, гүүрийн байгууламж	59,821,000.00	3,514,813,724.00
39,210	Хуримтлагдсан элэгдэл	(11,964,199.92)	(17,946,299.80)
39,214	Бусад үндсэн хөрөнгө	886,617,597.10	990,917,597.10
39,215	Хуримтлагдсан элэгдэл	(578,063,623.16)	(630,961,179.16)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>15,098,356.40</u></b>	<b><u>14,958,041.94</u></b>
39,301	Програм хангамж	9,173,239.00	9,943,239.00
39,302	Хуримтлагдсан элэгдэл	(5,444,882.60)	(6,355,197.06)
39,303	Бусад биет бус хөрөнгө	11,370,000.00	11,370,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,190,498,037.72</u></b>	<b><u>4,973,087,870.30</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,212,838,437.72</u></b>	<b><u>4,973,087,870.22</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>1,212,838,437.72</u></b>	<b><u>4,973,087,870.22</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,117,898,267.00	1,117,898,267.00
51,101	Өмч: - төрийн	1,117,898,267.00	1,117,898,267.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>(459,728,161.40)</u></b>	<b><u>3,300,521,271.10</u></b>

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51,210	Өмнөх үеийн үр дүн	(459,728,161.40)	(459,728,161.40)
51,220	Тайлант үеийн үр дүн	-	3,760,249,432.50
51,300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	554,668,332.12	554,668,332.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,212,838,437.72</u></b>	<b><u>4,973,087,870.22</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>631,690,224.00</b>	<b>4,743,559,696.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,520,000.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,520,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,520,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,520,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>621,170,224.00</b>	<b>4,743,559,696.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	95,331,609.00	3,868,320,774.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	95,331,609.00	3,868,320,774.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,387,415.00	9,729,322.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,387,415.00	9,729,322.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	521,451,200.00	865,509,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,451,200.00	865,509,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>613,758,992.79</b>	<b>983,310,263.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>613,758,992.79</b>	<b>983,310,263.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	609,265,108.79	940,637,263.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	378,429,278.04	648,724,065.29
210101	Үндсэн цалин	270,034,582.37	353,221,662.27
210102	Нэмэгдэл	107,678,695.67	276,239,930.02
210104	Урамшуулал	716,000.00	19,262,473.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,420,409.84	80,965,525.62
210201	Тэтгэврийн даатгал	47,420,409.84	80,965,525.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,016,000.00	30,756,992.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	37,891,000.00	29,256,992.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,800,165.00	32,045,322.00
210401	Бичиг хэрэг	1,860,050.00	2,761,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,274,015.00	23,862,522.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,711,300.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	698,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	254,800.00	370,000.00
210408	Бараа материал акталсны зардал	4,700,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	621,500.00	350,000.00
210502	Хоол, хүнс	330,000.00	-

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	291,500.00	350,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,854,000.00</b>	<b>2,126,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	314,000.00	502,000.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	62,000.00	47,000.00
210604	Урсгал засвар	1,478,000.00	1,577,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,258,000.00</b>	<b>8,950,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,258,000.00	8,950,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,405,766.00</b>	<b>14,025,258.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,851,216.00	11,822,158.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,500.00	513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	392,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	677,650.00	864,000.00
210807	Газрын төлбөр	131,000.00	128,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>88,459,989.91</b>	<b>122,693,500.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,580,000.00	8,850,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	710,300.00	1,002,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,169,689.91	112,840,950.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,493,884.00</b>	<b>42,673,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>714,000.00</b>	<b>40,273,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	38,622,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,651,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,779,884.00</b>	<b>2,400,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,779,884.00	2,400,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>17,931,231.21</u></b>	<b><u>3,760,249,432.50</u></b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>17,931,231.21</u></b>	<b><u>3,760,249,432.50</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>525,838,615.00</u></b>	<b><u>875,238,922.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>525,838,615.00</b>	<b>875,238,922.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,387,415.00</b>	<b>9,729,322.00</b>

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,387,415.00	9,729,322.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>521,451,200.00</b>	<b>865,509,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,451,200.00	865,509,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>525,158,615.00</u></b>	<b><u>872,238,922.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>525,158,615.00</b>	<b>872,238,922.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>520,664,731.00</b>	<b>829,565,922.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>378,915,600.00</b>	<b>648,733,000.00</b>
210101	Үндсэн цалин	257,574,964.33	349,945,000.00
210102	Нэмэгдэл	103,899,300.00	278,991,000.00
210104	Урамшуулал	12,441,335.67	19,797,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,000,000.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,650,000.00</b>	<b>81,091,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,722,000.00	55,142,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,732,000.00	6,487,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,985,600.00	3,243,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	746,400.00	3,243,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,464,000.00	12,974,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,016,000.00</b>	<b>30,756,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	37,891,000.00	29,256,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,344,715.00</b>	<b>33,312,822.00</b>
210401	Бичиг хэрэг	1,726,500.00	2,962,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,579,915.00	24,827,322.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,711,300.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	470,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>760,000.00</b>	<b>700,000.00</b>
210502	Хоол, хүнс	330,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,746,700.00</b>	<b>2,886,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	143,200.00
210604	Урсгал засвар	961,700.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,258,000.00</b>	<b>8,950,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,258,000.00	8,950,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,409,716.00</b>	<b>13,222,900.00</b>

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,725,316.00	10,858,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,500.00	513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	392,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	807,500.00	981,000.00
210807	Газрын төлбөр	131,000.00	128,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		44,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,564,000.00</b>	<b>9,912,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,850,000.00	8,850,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	1,062,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,493,884.00</b>	<b>42,673,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>714,000.00</b>	<b>40,273,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		38,622,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,651,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,779,884.00</b>	<b>2,400,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,779,884.00	2,400,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>680,000.00</u></b>	<b><u>3,000,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>680,000.00</b>	<b>3,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>680,000.00</b>	<b>3,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>680,000.00</b>	<b>3,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	680,000.00	3,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(680,000.00)</u></b>	<b><u>(3,000,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(0.00)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,117,898,267.00	554,668,332.12	-459,728,161.40	1,212,838,437.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	-459,728,161.40	1,212,838,437.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			3,760,249,432.50	3,760,249,432.50
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,117,898,267.00	554,668,332.12	3,300,521,271.10	4,973,087,870.22

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	521,451,200	517,671,316	865,509,600	865,509,600
21	УРСГАЛ ЗАРДАЛ	521,451,200	517,671,316	865,509,600	865,509,600

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	520,737,200	516,957,316	825,836,600	825,836,600
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	378,199,600	378,199,600	648,733,000	648,733,000
210101	Үндсэн цалин	264,300,300	257,574,964	349,945,000	349,945,000
210102	Нэмэгдэл	103,899,300	103,899,300	278,991,000	278,991,000
210104	Урамшуулал	5,000,000	11,725,336	19,797,000	19,797,000
210105	Гэрээт ажлын хөлс	5,000,000	5,000,000		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,650,000	46,650,000	81,091,200	81,091,200
210201	Тэтгэврийн даатгал	31,722,000	31,722,000	55,142,300	55,142,300
210202	Тэтгэмжийн даатгал	3,732,000	3,732,000	6,487,300	6,487,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,985,600	2,985,600	3,243,200	3,243,200
210204	Ажилгүйдлийн даатгал	746,400	746,400	3,243,700	3,243,700
210205	Эрүүл мэндийн даатгал	7,464,000	7,464,000	12,974,700	12,974,700
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,641,000	39,016,000	30,756,900	30,756,900
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000	1,125,000	1,500,000	1,500,000
210302	Түлш, халаалт	38,516,000	37,891,000	29,256,900	29,256,900
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,976,400	22,853,300	32,284,000	32,284,000
210401	Бичиг хэрэг	1,780,000	1,726,500	2,962,000	2,962,000
210402	Тээвэр, шатахуун	17,098,500	17,098,500	23,798,500	23,798,500
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900	3,701,300	4,353,500	4,353,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			700,000	700,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000	327,000	470,000	470,000
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	430,000	430,000	700,000	700,000

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000	430,000	700,000	700,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,885,000	1,746,700	2,886,600	2,886,600
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000	714,000	1,243,400	1,243,400
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000	71,000	143,200	143,200
210604	Урсгал засвар	1,100,000	961,700	1,500,000	1,500,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,037,000	4,258,000	8,100,000	8,100,000
210702	Дотоод албан томилолт	5,037,000	4,258,000	8,100,000	8,100,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,919,200	21,089,716	16,222,900	16,222,900
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,159,200	19,405,316	13,858,500	13,858,500
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,500	80,500	513,000	513,000
210803	Даатгалын үйлчилгээ	180,600	180,600	184,800	184,800
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800	399,800	392,800	392,800
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000	85,000	120,400	120,400
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000	807,500	981,000	981,000
210807	Газрын төлбөр	131,000	131,000	128,100	128,100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100		44,300	44,300
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,999,000	2,714,000	5,062,000	5,062,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,285,000	2,000,000	4,000,000	4,000,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000	714,000	1,062,000	1,062,000
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	714,000	714,000	39,673,000	39,673,000

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	714,000	714,000	39,673,000	39,673,000
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			38,622,000	38,622,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000	714,000	1,051,000	1,051,000
610002	Төсвөөс гадуур байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>23</b>	<b>23</b>	<b>22</b>
620001	Удирдах ажилтан	7	7	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	14	13
620003	Үйлчлэх ажилтан	6	6	6	6
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>22</b>	<b>23</b>	<b>22</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	15	15
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7	8	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,387,415.0</b>	<b>7,329,322</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,387,415.0</b>	<b>7,329,322</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,387,415.0	6,729,322
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	716,000.0	-
210104	Урамшуулал	716,000.0	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,491,415.0	1,028,822
210402	Тээвэр, шатахуун	1,481,415.0	1,028,822
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,000.0	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	330,000.0	-
210502	Хоол, хүнс	330,000.0	
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	-	850,000
210701	Гадаад албан томиллолт		

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт		850,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,850,000.0	4,850,500
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,850,000.0	4,850,500
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	600,000
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		600,000
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,779,884.0</b>	<b>2,400,000</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,779,884.0	2,400,000
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь нутгийн өөрөө удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Засаг даргын тамгын газрын тайлант оны зорилгыг "Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгож авлига, ашиг сонирхолын зөрчилд автахгүй үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах, байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдалыг хангах ажиллана" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд: "Төрөөс иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүрээнд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх"

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн СХШ/11 тоот удирдамжаар Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдэж, 0.4 сая төгрөгний төлбөрийн акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 299 дүгээр тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,760.2 сая төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	252.9	252.90	-
Урьдчилгаа	-	134.6	-134.6
Бараа материал	22,340.4	38,975.4	16,635.0
Үндсэн хөрөнгө	1,190,245.10	4,933,724.9	3,743,479.8
<b><u>Нийт хөрөнгө</u></b>	<b>1,212,838.4</b>	<b>4,973,087.8</b>	<b>3,760,249.4</b>
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,212,838.40	4,973,087.2	3,760,024.8
<b><u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u></b>	<b>1,212,838.40</b>	<b>4,973,087.2</b>	<b>3,760,024.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, авлагын дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 38.9 сая төгрөг болж 16.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 38.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 36.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж оны эцэст 38.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,933.7 сая төгрөг болж 3,743.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлт сумын төвийн 3 км хатуу хучилттай авто замыг ашиглалтанд авсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 3,760.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 522.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 522.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 327.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 849.9 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор анх баталсан төсвийг 15.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 875.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 875.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 872.8 сая төгрөг буюу 99.65 хувьтай байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80801	Үндсэн үйл ажиллагааны орлого	686,163.0	683,763.0	2,400.0	99.65%
80102	Туслах үйл ажиллагааны зардал	136,287.9	136,287.9	-	100.00%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	39,673.0	39,673.0	-	100.00%
80701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	13,115.0	13,115.0	-	100.00%
	<b>Дүн</b>	<b>875,238.9</b>	<b>872,238.9</b>	2,400.0	99.65%

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Засаг даргын тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Бусад нийтлэг АҮТХураамжийн данснаас нийт 13.9 сая төгрөгний зардал гарсан ба үүний 13.0 сая төгрөг нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зардалд зарцуулахаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 02 сарын 26-ны өдрийн 70 тоот хурлын тогтоолоор батлаж өгсөн төсвийн дагуу зарцуулсан.

Бусад бараа үйлчилгээний бусад данснаас 4.0 сая төгрөгний зардал гарсан ба энэ нь “Монгол баяглаг 330” төсөл хөтөлбөрийн хүрээнд Алтанцөгц сумын түүх, соёлын дурсгал болон соёлын өвийн бүртгэл мэдээлэлийн санг дүрсжүүлэн баримтжуулж, архив үүсгэх ажлын гэрээний дагуу зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 9.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, шагнал урамшуулалд 0.6 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 1.02 сая төгрөгийг, томилолтын зардалд 0.85 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 4.85 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Батлагдсан төсвийн хүрээнд 38.2 сая төгрөгийн бараа материал, 3.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 2/09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 613.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 983.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38.6 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.2 сая төгрөгийн зардлын 3 гүйлгээг хоцроож мэдээлсэн, хугацаа хоцролтын хэрэгжилт 84.6%-тай байна. Шилэн дансны хууль тогтоомжийн бүрэн хэрэгжүүлж ажиллахыг анхааруулав.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

2024 онд завсарын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4 төрлийн зөвлөмж өгөгдсөн ба дараах зөвлөмж биелэлт хэрэгжээгүй байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулан мэдээлж, зөрчлийг арилгах зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж цахим хуудсанд нөхөн байршуулах.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	0	3	0	75%
<b>Нийт дүн</b>	4	0	3	0	75%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 4.9 сая төгрөгийн зөрчилд<sup>1</sup> төлбөрийн 2 акт тогтоов.

1.Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 сарын 08-ны өдрийн Төлбөр төлөгчийн банк дахь харилцах данс битүүмжлэх, хасалт хийх тухай тогтоолын дагуу 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт С.Авдикадирын ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 5,412,841 төгрөгийг цалингийн зардлын төсвөөс шилжүүлэн барагдуулж, төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар зардал гаргасан байна.Уг зөрчилийг Алтанцөгц сумын засаг дарга Ш.Айбекээр нөхөн төлүүлэхээр Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 77 дугаартай албан шаардлага хүргүүлсэн боловч 1.0 сая төгрөгийг дутуу төлүүлсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

2. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшуулалын тооцоогоор Сумын Засаг даргын 2024 оны 05 сарын 03 өдрийн А/35 дугаар захирамжаар тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга нарт 19.0 сая төгрөгийн, Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 05 сарын 01-ний өдрийн А/13 дугаар тушаалаар 3 албан хаагчид 19.6 сая төгрөгний, нийт 38.6 сая төгрөгийн мөнгөн урамшуулалаас 3.8 сая төгрөгний хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна

*Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.” Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна*

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн зөрчилд<sup>2</sup> 1 албан шаардлага хүргүүлэв.

1.Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар санхүүгийн албаны даргад 1.4 сая төгрөгийн, нягтлан бодогчид 1.5 сая төгрөгийн 2023 оны жилийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсанээгж урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5-д “*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэжүүлнэ*”, 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байхыг албан шаардлага болгов.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар нийт 16.3 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрч, 12.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд нийт 117 нэр төрлийн 1999-2015 оны хооронд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 198.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, үлдэх өртөггүй, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталж данснаас хасах, ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх арга хэмжээ аваагүй байна

1.1. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө дээр бүртгэлтэй дээрх 117 нэр төрлийн 198.6 сая төгрөгийн хөрөнгийг Өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж холбогдох газруудад актлах санал хүргүүлэн, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах.

#### **2. Шатахууны зардалтай холбоотой асуудал**

2.1.Илрүүлэлт: Жолоочийн шатахууны зарцуулалтын тооцоог зохих журмын дагуу хийгээгүй, замын хуудасгүй 1.2 сая төгрөгийн, шатахууны талонгүй 0.4 сая төгрөгийн бензин зарцуулсан ба шатахууны зарцуулалтыг нормын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудсыг үнэн зөв хөтөлж, шатахууны зарцуулалтын тооцоог Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дугаар тушаалын "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалын дагуу тооцох.

#### **3.2024 оны ажилтнуудын ээлжийн амралттай холбоотой асуудал**

3.1.Илрүүлэлт: Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 09 сарын 3-ны өдрийн Б/16 тоот тушаалаар ажилтнуудын 2024 оны ээлжийн амралтын хуваарийг баталсан боловч тушаалын дагуу ажилтнуудад ээлжийн амралт олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.4, 99 дүгээр зүйлийн 99.1, 99.2, 99.8, 110 дугаар зүйлийн 110.1, заалтууд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын 1.2, 3.2 холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

---

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2. Өгсөн зөвлөмж:** Ажилтнуудын ээжлийн амралтыг тушаалын дагуу эдлүүлж, ээлжийн амралтын мөнгийг тухай бүрт бодож олгож байх.

**4. Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэнтэй холбоотой асуудал**

**4.1. Илрүүлэлт:** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зардалд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3 удаагийн гүйлгээгээр 8.3 сая төгрөгний зардал гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 заалтуудыг зөрчсөн байна.

**4.2. Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн бүрдүүлж авах, хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	3	6,402.3	1	1,000.0	1	2,923.0	1	2,479.3				
Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой	1	0					1	0				
Шатахууны тооцоотой холбоотой	1	1,580.1					1	1,580.1				
Хууль тогтоомж хэрэгжүүлж ажилаагүй	1	3,862.2	1	3,862.2								
Анхан шатны баримтгүй зарцуулсан	1	8,299.0					1	8,299.0				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>20,143.6</b>	<b>2</b>	<b>4,862.2</b>	<b>1</b>	<b>2,923.0</b>	<b>4</b>	<b>12,358.4</b>				

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
							-	-
Дүн								
<b>Нийт дүн</b>								